



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/33

Амардалай

Зардал гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоол Орон нутгийн Хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 8.5 дахь заалт, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 16-ний өдрийн 02 дугаар тогтоолын хавсралт 2 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сумын Орон нутгийн Хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Сумын төвийн гудамж талбайн гэрэлтүүлэг”-ийн зураг төсөв боловсруулах” зөвлөх үйлчилгээний зардал болон “Мал угаалгын ванн, мал эмнэлгийн ажил үйлчилгээ үзүүлэх зөөврийн хашаа”-ны зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний зардлыг Орон нутгийн Хөгжлийн сангаас зарцуулсугай.

Хоёр.Дээрх зардлын үнэ “Сумын төвийн гудамж талбайн гэрэлтүүлэг”-ийн зураг төсөв боловсруулах” зөвлөх үйлчилгээний зардал 1,578,342 төгрөгийг “ОСИБ-ЗТ” ХХК-ны дансанд, “Мал угаалгын ванн, мал эмнэлгийн ажил үйлчилгээ үзүүлэх зөөврийн хашаа”-ны зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний зардал 750,000 төгрөгийг “Классикхаус ХХК”-ны дансанд, Нийт 2,328.342 (Хоёр сая гурван зуун хорин найман мянга гурван зуун дөчин хоёр) төгрөгийг Сумын Орон нутгийн Хөгжлийн сангаас зориулалтын дагуу гаргаж зарцуулахыг нягтлан бодогч (Л.Амаржаргал)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

М.БАЯРСҮХ



2022.05.18